

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7-р сарын 10-наас 8-р сарын 07-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	VII/10	VII/17	VII/24	VII/31	VIII/07
1	Гурил, I зэрэг, кг	650	650	650	650	650
2	Хонины мах, кг/ ястай/	7500	7500	7000	7300	7000
3	Үхрийн мах, кг /ястай/	9500	9000	9000	8800	
4	Ямааны мах /ястай /	6500	6500	6500	6000	6000
5	Элсэн чихэр, кг	1480	1480	1480	1480	1480
6	Цагаан будаа, кг	1600	1600	1630	1630	1700
7	Шингэн сүү, л	700	700	700	700	700
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	55000				
9	- Бор ноолуур	55000				
10	Бензин, А-80, 1 литр	1550	1550	1550	1550	1550
11	Бензин, А-92, 1 литр	1650	1650	1650	1650	1650
12	Дизелийн түлш, 1 литр	1750	1750	1750	1750	1750

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2013 оны 7-р сарын 10-наас 8-р сарын 07-ны хооронд хонь, үхэр, ямааны ястай мах, цагаан будааы үнэ өөрчлөгдөж бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байв.

Махны үнэ. Хонины ястай мах 1 кг нь 7-р сарын 10, 17-нд 7500 төгрөг байсан бол 7-р сарын 24, 8-р сарын 7-нд 7000 төгрөг болж 6,7%-аар буурсан бол 7-р сарын 31-нд өмнөх 7 хоногоос 4,3%-аар нэмэгдэж 7300 төгрөг болов. Үхрийн ястай мах 7-р сарын 17-нд өмнөх 7 хоногоос 500 төгрөгөөр, 7-р сарын 31-нд дахин 200 төгрөгөөр тус тус буурч 1кг нь 8800 төгрөг болсныг 7-р сарын 10-ны ханштай харьцуулахад 7,4%, 7-р сарын 31-ний ханшаас 2,2%-аар буурав. Ямааны ястай мах 7-р сарын 31-нд өмнөх 7 хоногийн ханштай харьцуулахад 7,7%-аар буурч 6500 төгрөг болж энэ ханш хадгалагдсан хэвээр байна.

Цагаан будаа. Удаан хугацаанд өөрчлөлтгүй 1600 төгрөгийн үнэтэй байсан 1 кг цагаан будааны үнэ 7-р сарын 24-нөөс 1,85%-аар өссөн бол 8-р сарын 7-нд өмнөх сартай харьцуулахад 4,3%-аар дахин өсөв.

Ямааны ноолуур бор, цагаан өнгө ялгалгүй ижил үнэтэй байна. Ноолуурын арилжаа зогсонги байдалтай болж 7-р сарын 10-нд 55000 төгрөгийн ханштай байв.



